



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг



МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИЙН ЗАГВАР БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ (2020-2022)



Д.Кадирбек ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургууль

Н.Очирхүү ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль



АГУУЛГА

Зургийн жагсаалт.....	1
Хавсралтын жагсаалт	1
Хүснэгтийн жагсаалт	2
Удиртгал	3
Бизнес төлөвлөгөөний хураангуй	4
1. Мал эмнэлгийн нэгжийн танилцуулга.....	5
1.1. Нэгжийн үндсэн мэдээлэл	5
1.2. Хувь нийлүүлэгчдийн талаарх мэдээлэл.....	5
1.3. Товч түүх.....	5
1.4. Компанийн хөрөнгө, өр авлага.....	5
1.5. Зээлийн түүх	6
1.6. Барьцаа хөрөнгө.....	6
2. Нөхцөл байдлын шинжилгээ.....	6
2.1. Дам нөлөөтэй гадаад орчны судалгаа	6
2.2. Шууд нөлөөтэй гадаад орчны судалгаа	7
2.2.1. Зах зээлийн ерөнхий мэдээлэл	7
2.2.2. Нийлүүлэгчийн судалгаа.....	8
2.3. Дотоод орчны судалгаа буюу үйл ажиллагааны шинжилгээ.....	8
2.3.1. SWOT шинжилгээ.....	8
2.3.2. Стандартын шаардлагын талаарх судалгаа	10
2.3.3. Үйл ажиллагааны төрөл, тоо хэмжээ.....	11
3. Зорилго, зорилтууд.....	Error! Bookmark not defined.
3.1. Эрхэм зорилго.....	Error! Bookmark not defined.
3.2. Зорилтууд	12
4. Маркетингийн төлөвлөгөө	12
4.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээ.....	12
4.2. Үнийн бодлого.....	13
4.3. Идэвхжүүлэлт	14
4.4. Борлуулалт, түгээлт.....	15
5. Үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөө	16
5.1. Үйл ажиллагааны төлөвлөгөө	16
5.2. Түүхий эд, материалын төлөвлөгөө.....	18
6. Менежментийн төлөвлөгөө	18
7. Хөрөнгө оруулалт, санхүүгийн төлөвлөгөө.....	19
7.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө.....	19
7.2. Борлуулалтын орлогын төлөвлөгөө.....	20
7.3. Зардлын төлөвлөгөө	20
7.3.1. Түүхий эд, материалын зардал	20
7.3.2. Цалингийн зардал	21
7.3.3. Хөдөлмөр хамгааллын зардал	21
7.3.4. Шатахууны зардал.....	21
7.3.5. Цахилгаан, дулааны зардал.....	22

7.3.6. Элэгдлийн зардал.....	22
7.3.7. Харилцаа холбоо, бичиг хэрэг, шуудан холбооны зардал.....	22
7.3.8. Зардлын нэгтгэл.....	23
7.4. Үр ашгийн тооцоо	23
8. Эрсдэлийн үнэлгээ.....	24
Зөвлөмж.....	26
Хавсралтууд.....	27

Зургийн жагсаалт

Зураг 1. 2019 онд үзүүлсэн үйлчилгээний тоо, төрлөөр	11
Зураг 2. Бичигт багийн малын тооны өөрчлөлт	15
Зураг 3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн зохион байгуулалтын хэлбэр.....	19
Зураг 4. Орлого, зардал, үр ашиг, мянган төгрөг	23

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Байвал зохих болон байгаа багаж, төхөөрөмжийн жагсаалт, үнийн дүн, мян.төг	27
--	----

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Борсүмбэр ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн мэдээлэл	5
Хүснэгт 2. Компанийн баланс	5
Хүснэгт 3. Зээлийн түүх	6
Хүснэгт 4. Барьцаа хөрөнгө	6
Хүснэгт 5. Дам нөлөөтэй гадаа орчны судалгаа	6
Хүснэгт 6. Зах зээлийн ерөнхий мэдээлэл	7
Хүснэгт 7. Нийлүүлэгчийн мэдээлэл	8
Хүснэгт 8. SWOT шинжилгээ	8
Хүснэгт 9. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5368: 2018 стандартын шаардлагуудыг хангаж буй байдал	10
Хүснэгт 10. Стандартын шаардлагыг багаж, төхөөрөмжийн хувьд хэрхэн хангаж байгаа байдал ..	11
Хүснэгт 11. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл	13
Хүснэгт 12. Төв аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний жишиг үнэлгээ	14
Хүснэгт 13. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааны график, жилээр	16
Хүснэгт 14. Үйлчилгээний төрөл, тоо хэмжээ	17
Хүснэгт 15. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, мянган төгрөг	19
Хүснэгт 16. Борлуулалтын орлого, мянган төгрөг	20
Хүснэгт 17. Эм, тариа, бусад түүхий эд материалын зардлын тооцоо, мянган төгрөг	21
Хүснэгт 18. Цалингийн зардал, мянган төгрөг	21
Хүснэгт 19. Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн зардал, мянган төгрөг	21
Хүснэгт 20. Шатахууны зардал, мянган төгрөг	21
Хүснэгт 21. Эрчим хүчний зардал, мянган төгрөг	22
Хүснэгт 22. Элэгдлийн зардал, мянган төгрөг	22
Хүснэгт 23. Харилцаа холбоо, бичиг хэрэг, шуудан холбооны зардал, мянган төгрөг	22
Хүснэгт 24. Зардлын нэгтгэл, мянган төгрөг	23
Хүснэгт 25. Эрсдлүүд, даван туулах, бууруулах арга замууд	24

Удиртгал

Монгол улс 1990 оноос зах зээлийн харилцаанд шилжин улс орны нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт шинэчлэл, өөрчлөлт явагдсаны хүрээнд 1999 онд сум, дүүргийн мал эмнэлгийн нэгжүүд хувьчлагдсан. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хувьчлагдсанаас хойш 20 гаруй жил өнгөрч байгаа хэдий ч материаллаг баазын хувьд бүрэн бэхжээгүй, багаж, тоног төхөөрөмж дутмаг, техник, хэрэгсэл нь хуучирч муудсан, хөдөлмөр хөнгөвчлөх орчин үеийн технологи нэвтрээгүй, бизнес төлөвлөгөө байхгүй, санхүүгийн бүртгэл, эдийн засгийн тооцоо муутайн улмаас өнөөг хүртэл бизнесийн байгууллагын хэмжээнд хүртэл бүрэн төлөвшиж чадаагүй байна. Үүнд нөлөөлж буй олон хүчин зүйл байгаа хэдий ч орон нутагт ажиллаж байгаа ихэнх малын эмч нар бизнес сэтгэлгээ, эдийн засаг, санхүүгийн мэдлэг багатайн улмаас ашиг орлогоо нэмэгдүүлж мал эмнэлгийн үйлчилгээний бизнесээ өргөжүүлэн хөгжүүлж чадахгүй байна. Мөн “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 30.5.2-д мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь үйл ажиллагаа явуулах бизнес төлөвлөөтэй байна гэж заасан нь бүх мал эмнэлгийн нэгжүүд бизнес төлөвлөгөө боловсруулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгох шаардлагатайг баталгаажуулсан байдаг.

Иймээс үйлдвэрлэлд ажиллаж буй малын эмч нарын бизнес, эдийн засаг, менежментийн мэдлэгийг нэмэгдүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бизнес төлөвлөгөө хэрхэн яаж боловсруулах ур чадвар олгох зорилгоор Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн хүрээнд МЭҮН-ийн зардал-үр ашгийн шинжилгээ хийж “Бизнес төлөвлөгөөний загвар” боловсруулах гэрээт ажлыг гүйцэтгэлээ. Тус гэрээт ажлын хүрээнд Төв аймгийн Батсүмбэр сумын Ивомек ХХК, Чандмань Оточ ХХК, Борнуур сумын Монгол Ханд ХХК, Сүүж Хад ББН-ийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг сонгон үйл ажиллагаа, материаллаг бааз, хүний нөөц, харилцагч түншүүд, хэрэглэгчид, орлого, зарлага болон тулгарч буй бэрхшээлийг судалж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулах талаар өөрсдийн болон бусад судлаачдын өмнө нь хийж байсан судалгааны үр дүнтэй харьцуулан дүн шинжилгээ хийж энэхүү “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бизнес төлөвлөгөөний загвар”-ыг боловсруулан гаргав. Энэхүү бизнес төлөвлөгөөний загварт ашигласан мэдээлэл, баримт, тоон үзүүлэлтүүд нь судалгаанд хамрагдсан 4 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаа болон бусад үзүүлэлтийн дундаас нэгтгэж гаргаж авсан дундаж үзүүлэлтүүд бөгөөд ямар нэг байгууллагын санхүү, үйл ажиллагааг төлөөлөхгүй болно.

Бидний боловсруулсан бизнес төлөвлөгөөний загвар нь мал эмнэлгийн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаагаа идвэхжүүлэх, үйлдвэрлэл болон үйлчилгээний нэр төрлөө нэмэгдүүлэх, зах зээлээ өргөжүүлэх, тулгарч буй хүндрэл бэрхшээлээ даван туулах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, байгууллагын менежментийг сайжруулах, эдийн засгийн үр ашгаа нэмэгдүүлэхэд шинэ санаа өгөх улмаар малын эмч нар бизнес төлөвлөгөөгөө өөрсдөө боловсруулж сурахад бага ч атугай тус болно гэдэгт итгэж байна.

Зохиогчид

Бизнес төлөвлөгөөний хураангуй

Аж ахуйн нэгжийн нэр, хувь эзэмшигч, туршлага:	Борсүмбэр ХХК - 2000 онд байгуулагдсан, нэг хувь эзэмшигчтэй; - Нэг ажилтантай – захирал, малын эмч. - Компанийн захирал нь малын их эмч мэргэжилтэй, 33 жил малын эмчээр дагнан ажилласан туршлагатай.
Эрхэм зорилго:	Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, стандарт, мал эмнэлгийн ерөнхий болон төрөлжсөн үйлчилгээний орчин үеийн шаардлагыг бүрэн хангасан, нэгдүгээр зэрэглэлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж болох.
Зорилтууд:	• Малчидтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх • Угаалгын ваннтай болох • Мал эмнэлгийн зориулалттай стандартын шаардлага бүрэн хангасан байртай болох • Мал, амьтны өвчний анхан шатны оношлогоо, түүхий эд бүтээгдэхүүнд чанар, аюулгүйн шинжилгээ хийх лабораторитой болох • Мал эмнэлгийн үйлчилгээнд технологийн шинэчлэл хийх • Бусад мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтарч ажиллах
Хэрэгжүүлэх хугацаа:	2020-2022 он, 3 жилийн хугацаатай
Төслийн нийт хөрөнгө оруулалт:	113.5 сая төгрөг , үүнээс: - Өөрийн хөрөнгөөр – 43.5 сая төгрөг ○ 2021 онд 13.0, 2022 онд 30.5 сая төгрөг; - Улсын төсвөөс – 50.0 сая төгрөг ○ 2022- 50.0 сая төгрөг; - Орон нутгийн хөгжлийн сангаас – 20.0 сая төгрөг ○ 2020-20.0 сая төгрөг;
Үйлчилгээний төрөл:	- Дуудлагын үйлчилгээ, эмчилгээ (эмийн борлуулалт ороод) - Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт - Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ - Ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ - Мал эмнэлгийн гэрчилгээ олгох үйлчилгээ
Орлогын хэмжээ:	○ 2020 – 47.6 сая төгрөг ○ 2021 – 51.5 сая төгрөг ○ 2022 – 56.1 сая төгрөг
Цэвэр ашгийн хэмжээ:	○ 2020 – (3.3) сая төгрөг ○ 2021 – (3.6) сая төгрөг ○ 2022 – (3.3) сая төгрөг

1. Мал эмнэлгийн нэгжийн танилцуулга

1.1. Нэгжийн үндсэн мэдээлэл

Байгууллагын нэр	“Борсүмбэр” ХХК
Аж ахуйн нэгжийн төрөл	ХХК
Утасны дугаар	9999-9999
Хаяг	Төв аймгийн Борнуур сум
Улсын бүртгэлийн дугаар	9999-999
Байгуулагдсан огноо	2000 он
Хүлээх хариуцлага, эрсдэл ба ашиг хуваах	Нэг хүний эзэмшлийн аж ахуйн нэгж
Үйл ажиллагааны чиглэл	Мал эмнэлгийн үйлчилгээ

1.2. Хувь нийлүүлэгчдийн талаарх мэдээлэл

Хүснэгт 1. Борсүмбэр ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн мэдээлэл

№	Хувь нийлүүлэгчийн нэр	Нийлүүлсэн хөрөнгө /мян. төгрөг/	Хувь
1	Б.Бор	1000.0	100.0
2			
Нийт		1000.0	100.0

1.3. Товч түүх

Борсүмбэр ХХК нь 2000 онд байгуулагдсан. Борнуур сумын 3-р багийн малчид, фермерүүд болон Засаг даргатай гурвалсан гэрээ байгуулан тус багийн айл, өрхүүдийн мал, сүргийг бүх төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эдийн чанар, аюулгүй байдлын баталгаа гаргах зэргээр мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг.

Тус компани мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл бүхий малын эмчтэй бөгөөд мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх, шимэгчтэх өвчнийг эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалт хийх үед түр хугацаагаар санитарч авч ажиллуулдаг. Материаллаг баазын хувьд бүрэн бэхжиж чадаагүй ба стандартын шаардлага хангасан зориулалтын байр, лаборатори байхгүй, тоног төхөөрөмж дутагдалтай.

Цаашид стандартын шаардлага хангасан байр, лаборатори, тоног төхөөрөмжтэй болох, үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байгаа.

1.4. Компанийн хөрөнгө, өр авлага

Компани нь одоогийн байдлаар дансандаа 500.0 мянган төгрөгтэй, 8.0 сая төгрөгийн барилга, байгууламж, 13.3 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжтэй. Богино болон урт хугацаат өр төлбөр байхгүй, 21.8 сая төгрөгийн эздийн өмчтэй. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Компанийн баланс

Хөрөнгө	Үнэлгээ, мян.төг.	Өртөлбөрбаазнийөмч	Үнэлгээ, мян.төг.
Бэлэн мөнгө	500,000.0	Богино хугацааны өр төлбөр	0.0
Барилга, байгууламж	8,000,000.0	Урт хугацааны өр төлбөр	0.0

Машин, тоног төхөөрөмж	13,333,000.0	Эздийн өмч	21,833,000.0
ДҮН	21,833,000.0		21,833,000.0

1.5. Зээлийн түүх

Компани дээр бүртгэлтэй, шаардлага хангасан барьцаа хөрөнгө байхгүй тул одоогоор компанийн нэрээр зээл авч байгаагүй.

Хүснэгт3. Зээлийн түүх

№	Банк	Зээлийн хэмжээ	Огноо	Хугацаа	Хүү	Эргэн төлөлт
1						

1.6. Барьцаа хөрөнгө

Компани дээр бүртгэлтэй, шаардлага хангасан барьцаа хөрөнгө үгүй.

Хүснэгт4. Барьцаа хөрөнгө

	Барьцаа	Байршил /төрөл/	Тоохэмжээ	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг	Тайлбар
1						
2						

2. Нөхцөл байдлын шинжилгээ

2.1. Дам нөлөөтэй гадаад орчны судалгаа

Хүснэгт 5. Дам нөлөөтэй гадаад орчны судалгаа

<i>Улс төрийн орчин</i> - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар байгуулагдахаас өмнө улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газар, Сайд, Мал эмнэлгийн салбарын удирдах албан тушаалтан өөрчлөгдөх бүрт мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал эмнэлгийн нэгжүүд болон малын эмч нарыг дэмжих төрийн бодлогууд өөрчлөгдөж, урьд өмнө нь төлөвлөгдөн хийгдэж байсан ажлууд зогсож дахин өөр бодлого, зорилтыг дэвшүүлэн ажилладаг байдал ажиглагддаг нь ажлын үр дүнг бууруулдаг. 2018 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газар, аймгуудад Мал эмнэлгийн газар, сумдад Мал эмнэлгийн тасаг байгуулагдсанаар орон нутагт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгтэй тэмцэх, эрүүлжүүлэх, хүнсний аюулгүй байдлын баталгааг хангахад тодорхой ахиц дэвшил гарч байна. - Улс төрийн нөхцөл байдал, тэр дундаа аймаг, сумдын төр захиргааны байгууллагуудын зарим албан тушаалтнууд солигдоход мал амьтны өвчинтэй тэмцэх, мал эмнэлгийн	<i>Нийгэм, соёлын орчин</i> - Мал эмнэлгийн нэгжүүдийн ихэнх нь стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмж байхгүй, үйлчилгээний технологи хуучирсан, мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори байхгүй, орлого багатайн улмаас хөгжихгүй байгаа нь малын эмч нарын нийгэм дэх үнэлэмжийг бууруулж байна. - Орон нутгийн (аймаг, сум) -ийн газарзүйн байршил, малын тоо, газар нутгийн хэмжээ, халдварт, шимэгчтэх өвчний тархварзүй, мал аж ахуй эрхлэх хэлбэр (бэлчээрийн болон фермерийн мал аж ахуй) харилцан адилгүй тул мал эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл, хэлбэр, чанар, хүртээмж болон малын эмч нарын ур чадвар сум бүрт ялгаатай зэрэг олон хүчин зүйлээс болж иргэд, малчдын мал эмнэлгийн үйлчилгээний талаарх үзэл бодол, хандлага, үнэлэмж ялгаатай байдаг. - Ихэнх малчид, фермерүүд мал эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөрөө цаг тухайд нь төлж хэвшээгүй, аль болох үнэгүй үйлчилгээ авахыг эрмэлздэг. Өөрөөр хэлбэл ихэнх иргэд хуучин тогтолцооны бэлэнчлэх сэтгэлгээнээсээ одоо болтол салаагүй байна. - Малчид өөрийн харьяа орон нутгийн гэрээт малын эмчдээ хандаж мал эмнэлгийн
--	---

үйлчилгээний нэгжүүдийг дэмжих орон нутгийн бодлого өөрчлөгдөх явдал тохиолддог. Мал эмнэлгийн салбарын байгууллагын удирдлагын халаа, сэлгээ, зарим албан тушаалтны хариуцлагагүй байдлаас болж орон нутагт жил бүр гардаг халдварт өвчний вакцин графикт хугацаанд ирэхгүй байх, захиалсан тооноосоо дутуу ирэх явдал нэлээд гардаг. Энэ нь төлөвлөгөөт ажил цалгардуулах, тухайн вакцины дархлаа тогтоох идвэхийг бууруулах, вакцинжуулалтын технологийн горимыг алдагдуулах, улмаар уг ажлыг хийхэд гарах зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог.	үйлчилгээ авахын оронд Улаанбаатар хотын малын эмийн сангаас өөрийн дураар аль болох хямд, чанарын баталгаатай эсэх нь тодорхойгүй эм, тариа худалдан авч малаа өөрсдөө дур мэдэн эмчлэх (туулга олгох, боловсруулалт хийх, антибиотик тарих гэх мэт) -ийг оролддог байдал түгээмэд бөгөөд уг хандлага нь малчид, фермерүүдийн дунд хэвшмэл болох хандлагатай байна. Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг борлуулахын өмнө лабораторийн шинжилгээнд хамруулах сэтгэлгээ малчид, иргэдийн дунд төлөвшөөгүй, аль болох мал эмнэлгийн гэрчилгээ авахгүйгээр түүхий эд бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулахыг эрмэлздэг.
<i>Хууль эрх зүйн орчин</i> - Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль УИХ-аар 2017 оны 12 сард батлагдан гарч 2018 оны 06 сараас улс орон даяар хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулж оролцогч талуудын, тэр дундаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаа, эрх, үүргийг тодорхой зааж өгсөн. - Мөн уг хуулийг дагалдан мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хянах, хүнсний аюулгүй байдлыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбоотой дүрэм, журам, шаардлага, стандарт, зааварууд батлагдан хэрэгжиж байна. - Мал эмнэлгийн салбарын хувьд хууль, эрхзүйн орчин шинэчлэгдсэн боловч уг хууль, холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилт орон нутагт хангалтгүй байгаа нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж, өрсөлдөх чадвар, ашиг орлогод сөргөөр нөлөөлсөөр байна.	<i>Эдийн засгийн орчин</i> - Улсын болон орон нутгийн төсвөөс олгодог халдварт өвчний вакцины үйлчилгээний хөлсийг цаг тухайд нь бүрэн олгодоггүй нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаанд тодорхой хүндрэл учруулдаг. - Улсын эдийн засаг тогтворгүй, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ бага байгаа нь малчид, иргэдийн худалдан авах чадварт шууд нөлөөлж орлого багатай малчид, фермерүүд мал эмнэлгийн үйлчилгээний төлбөрөө төлж чадахгүй байна. - Улсын болон орон нутгийн төсвөөс олгодог халдварт өвчний вакцины үйлчилгээний хөлс болон аймгийн ИТХ-аар баталсан мал эмнэлгийн үйлчилгээний жишиг үнийн тариф бага байгаа нь мал эмнэлгийн нэгжүүдийн ашиг, орлогод сөргөөр нөлөөлж байна. - Засгийн газраас малын эрүүл мэндийг хамгаалах талаар хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн хүрээнд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг эдийн засгийн хувьд дэмжсэн бодлого боловсруулж, бодитой арга хэмжээ авч чадахгүй байгаа тул мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд бие дааж материаллаг бааз, технологийн шинэчлэл хийж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжгүй, амиа аргацаасан байдалтай байна.

2.2. Шууд нөлөөтэй гадаад орчны судалгаа

2.2.1. Зах зээлийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 6. Зах зээлийн ерөнхий мэдээлэл

<i>Зорилтот зах зээл</i>	Төв аймгийн Борнуур сумын малчид, фермерүүдийн мал сүрэгт мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх замаар бизнесийн үйл ажиллагаа эрхлэх.
<i>Хэрэглэгчдийн</i>	Сумын хэмжээнд 810 малчин болон мал бүхий өрхийн 10,820 адуу, 14,830

тоо	үхэр, 40,300 хонь, 35,870 ямаа, 50 тэмээ, нийт 101,860 мал амьтан.
Өрсөлдөгчдийн тоо	Сумын хэмжээнд 810 малчин болон мал бүхий өрхийн 101,860 мал сүрэгт мал эмнэлгийн үйлчилгээний 3 нэгж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Тус гурван үйлчилгээний нэгж нь малчин өрхүүдийг байршил болон багаар нь хувааж авсан ба өөр өөрсдийн хариуцсан өрхүүдэд л үйлчилгээ үзүүлдэг тул өрсөлдөгч байхгүй гэж ойлгож болно.

2.2.2. Нийлүүлэгчийн судалгаа

Хүснэгт 7. Нийлүүлэгчийн мэдээлэл

Нийлүүлэгчийн нэр	Нийлүүлэхтүүхий эд	Үйлдвэрлэгчээс хэр хол зайтай байдаг, км	Тээврийн зардал, төгрөг
Монветмед ХХК	Эм, тариа, туулга	86 км	30,000 төгрөг - нэг удаад
Малчин монгол ХХК			
Чонос импрайд ХХК			
Агриматко-Монгол ХХК			
Глобал линк ХХК			
Ви.ти.нет			
Биокомбинат ААТУУГ	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин	130 км	50,000 төгрөг – нэг удаад

2.3. Дотоод орчны судалгаа буюу үйл ажиллагааны шинжилгээ

2.3.1. SWOT шинжилгээ

Хүснэгт 8. SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i> - Тухайн орон нутагт мал эмнэлгийн нэгж байгуулан 20 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа тул найдвартай байнгын үйлчлүүлэгчидтэй болсон. - Малын эмч нь мэргэжлийн ур чадвар сайтай, олон жилийн туршлагатай тул малчдын дунд нэр хүндтэй. - Мал эмнэлгийн үйлчилгээний бизнес эрхлэх боломж тухайн орон нутгийн байнгын оршин суугч малын эмчид хуулиар олгогдож эрх нь баталгаажсан тул өрсөлдөгч гарч ирэх магадлал бага.	<i>Сул тал</i> - Мал эмнэлгийн нэгжид ажиллах малын эмчийн нас өндөр (дундажаар 55) болсон тул ажлын бүтээмж, чадамж буурсан. - Малын эмч компанийн захирлын ч, ажилчны ч үүргийг гүйцэтгэдэг тул маш их ядарч, стрессддэг, төлөвлөгөө, тооцоогүйгээр ажилладаг тул үр ашиггүй, амиа аргацаасан маягаар ажилладаг. - Мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори байхгүй тул тухайн орон нутгаас нийтийн хэрэгцээнд нийлүүлэгдэж буй малын гаралтай хүнсний болон түүхий эд бүтээгдэхүүний шинжилгээ хийх боломжгүй, зөвхөн мал, амьтны өвчний тархварүй, мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан байдалд үндэслэн мал эмнэлгийн гэрчилгээ олгодог. - Ихэнх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл элэгдэж хуучирсан, хоцрогдсон. - Суурин болон зөөврийн ванн байхгүй тул мал угаалгын арга хэмжээг бүрэн, чанартай хийх боломж хязгаарлагдмал. - Мал хаших зориулалтын зөөврийн хашаа байхгүй тул мал эмнэлгийн ажил, үйлчилгээ хийхэд ихээхэн хүндрэл гардаг. - Мал эмнэлгийн үйлчилгээний үнэ тариф бага тул ашигт ажиллагаа доогуур, иймд хөрөнгө оруулалт хийж техник, тоног
---	---

	төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах боломжгүй.
<i>Боломж</i> • Төр засгаас мал сүргийг эрүүлжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах талаар анхаарч хууль, эрхзүйн орчныг шинэчилснээр мал нэг бүрийг төрийн оролцоотойгоор мал эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамруулах боломжтой болсон ба малын эмч нар өөрсдөө идвэхи, санаачлага гаргаж ажиллаж чадвал тэр хэрээр орлогоо нэмэгдүүлэх боломж бүрэн нээгдсэн болсон. • Мал эмнэлгийн эрхзүйн орчин шинэчлэгдсэнээр малын шилжилт хөдөлгөөн ба нийтийн хэрэгцээнд нийлүүлэгдэж буй малын гаралтай хүнсний болон түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгож эхэлсэн нь уг гэрчилгээг хуурамчаар үйлддэг байсан зөрчлийг арилгаж гагцхүү малын эмч нар гэрчилгээ бичиж орлогоо нэмэгдүүлэх боломжийг нээж өгсөн. • Нийтийн хэрэгцээнд зориулж нийлүүлж, зарж буй мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн (мах-махан бүтээгдэхүүн, сүү-сүүн бүтээгдэхүүн, өндөг, загас гэх мэт) болон түүхий эд (арьс, шир, ноос, ноолуур) - ийн чанар, аюулгүй байдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулсан байх шаардлагыг төр засгийн зүгээс тавьж байгаа нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори байгуулан ажиллуулж орлогоо нэмэгдүүлэх боломжийг бий байна. • Олон улсын болон сум, орон нутаг хөгжүүлэх сангийн төсөл, хөтөлбөрт хамрагдаж барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээ сайжруулах, технологийн шинэчлэл хийх, үйлчилгээний нэр төрлөө олшруулах замаар зах зээлээ тэлэх боломжтой. • Төр засгийн зүгээс малын эрүүл мэндийг хамгаалах болон хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг шинэчилж мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг дэмжих бодлого хэрэгжүүлж эхэлж байгаа нь мал эмнэлэгт хандах малчид, иргэдийн хандлагыг өөрчилж гэрээт малын эмчээсээ мал эмнэлгийн үйлчилгээ авах дамтамжийг нэмэгдүүлсэн. • Сум, орон нутагт ажиллаж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хөрөнгө, санхүү болон хөдөлмөрөөрөө нэгдэн нөхөрлөл байгуулж, материаллаг баазаа өргөтгөж, стандартын шаардлага хангасан мал эмнэлэг болж хөгжих боломж байна.	<i>Аюул</i> • Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид тавигдах хуулийн болон стандартын шаардлага, үүнд барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн шаардлага хэт өндөр. • Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулахад гарах зардал өндөр, ашигт ажиллагаа бага, малын эмч нарын нийгэм дэх үнэлэмж доогуур тул шинээр төгссөн малын эмч нар мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулан ажиллах нөхцөл бүрдээгүй. • Орон нутагт ажиллаж буй ихэнхи мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарын дундаж нас өндөрболсон,гэд залгамж халаагаа бэлтгээгүйн байдал ньцаашид тухайн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаа доголдоход нөлөөлж болзошгүй. • Малчид мал эмнэлгийн үйлчилгээг малын эмчээр хийлгэж, үйлчилгээний хөлсийг тухай бүр өгч, төлбөртэй үйлчилгээ авч хэвшээгүй, хуучин тогтолцооны бэлэнчлэх сэтгэлгээнээс салаагүй байгаа нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ашигт ажиллагаа, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. • Ихэнх малчдын мөнгөн орлого улирлаас хамааралтай байдаг тул мал сүрэгтээ байнга мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч чаддаггүй, энэ нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ашиг, орлогод сөргөөр нөлөөлдөг. • Зарим малчид орон нутгийн гэрээт малын эмчдээ хандаж мал эмнэлгийн үйлчилгээ авахын оронд Улаанбаатар хотын худалдааны төвүүдээр борлуулагддаг хямд, чанарын баталгаатай эсэх нь тодорхойгүй эм, тариа худалдан авч малаа өөрсдөө дур мэдэн эмчлэхийг оролддог нь хэвшмэл болох хандлагатай. • Малыг гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг борлуулахын өмнө лабораторийн шинжилгээнд хамруулах сэтгэлгээ малчид, иргэдийн дунд төлөвшөөгүй.

2.3.2. Стандартын шаардлагын талаарх судалгаа

Тус мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа” -ны MNS 5368: 2018 стандартын шаардлагуудыг хэрхэн хангаж байгааг судалж үзлээ. Стандартын шаардлагуудыг Мал эмнэлгийн үйлчилгээний ерөнхий шаардлага, Мал эмнэлгийн ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний нэгжид тавих шаардлага гэж хоёр бүлэг болгож, бүлэг дотор нь хэд хэдэн зүйл болгосон. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид стандартын дагуу байвал зохих зүйл бүрийг нэг оноогоор үнэлэхэд нийт 121 оноо авах ёстой ба үүнээс 29 нь ерөнхий шаардлага, 92 нь тусгай шаардлага юм.

Тус мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь нийт шаардлагын 60 орчим хувийг, Мал эмнэлгийн үйлчилгээний ерөнхий шаардлагын хувьд 69 хувийг хангаж байгаа бол Мал эмнэлгийн ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний нэгжид тавих шаардлагын тухайд 57 хувь буюу хангалтгүй үзүүлэлттэй байна. Үүнд, ялангуяа, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг шинжилгээ хийх чадавхын хувьд дөнгөж 18, халдварт, шимэгчтэх өвчний оношилгоо, шинжилгээ хийх шаардлагын хувьд 25, барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй холбоотой тусгай шаардлагын хувьд 44 хувийг тус тус хангаж байгаа нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг чадавхжуулах, барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэх талаар бодитой дэмжлэг шаардлагатай байгааг харуулна.

Хүснэгт 9. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5368: 2018 стандартын шаардлагуудыг хангаж буй байдал

№	Шаардлагууд	Авбал зохих оноо	Авсан оноо	Хувь
1	Мал эмнэлгийн үйлчилгээний ерөнхий шаардлага	29	20	69%
1.1	Барилга байгууламж, тоног төхөөрөмж	9	3	33%
1.2	Хүний нөөц	2	1	50%
1.3	Үйл ажиллагаа	2	2	100%
1.4	Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	16	14	88%
2	Мал эмнэлгийн ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний нэгжид тавих шаардлага	92	52	57%
2.1	Нийтлэг шаардлага	6	4	67%
2.2	Тусгай шаардлага	39	17	44%
2.3	Халдваргүй өвчний оношилгоо, эмчилгээ	18	17	94%
2.4	Халдварт, шимэгчтэх өвчний оношилгоо, шинжилгээ	8	2	25%
2.5	Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг шинжилгээ	11	2	18%
2.6	Ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний нэгжийн эм, бэлдмэлийн нөөц	10	10	100%
Дүн		121	72	60%

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид байвал зохих болон байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг харьцуулж үзлээ. Стандарт шаардлагын дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мал эмнэлгийн ажил, үйлчилгээнд нийтлэг шаардагдах 29, лабораторийн 23, тавилга эд хогшлын 9 нэр төрлийн, нийт 61 тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байвал зохино. Гэвч тус нэгж нь нийт 28 нэр төрлийн багаж, хэрэгсэлтэй байгаа нь стандартын шаардлагын 46 хувийг ерөнхийдөө хангаж байна гэсэн үг. Харин үнийн дүнгийн хувьд 56.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байх ёстой бол тус нэгжид одоо бүртгэлтэй байгаа нь 13.3 сая төгрөг байгаа нь шаардлагыг дөнгөж 23 хувьтай хангаж байна.

Хүснэгт 10. Стандартын шаардлагыг багаж, төхөөрөмжийн хувьд хэрхэн хангаж байгаа байдал¹

Нэр төрөл	Байвал зохих		Байгаа		Хувь	
	Төрөл	Үнийн дүн, мян. төг.	Төрөл	Үнийн дүн, мян. төг.	Төрөлд	Үнийн дүнд
1. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээнд нийтлэг шаардагдах багаж, төхөөрөмж	29	33,719.5	14	7,936.0	48%	24%
2. Лабораторийн багаж хэрэгсэл	23	15,215.0	5	2,701.0	22%	18%
3. Тавилга, эд хогшил	9	7,875.0	9	2,696.0	100%	34%
Дүн	61	56,809.5	28	13,333.0	46%	23%

2.3.3. Үйл ажиллагааны төрөл, тоо хэмжээ

Компанийн 2019 онд үзүүлсэн үйлчилгээг төрөл тус бүрээр нь Зураг 1-т харуулав.



Зураг 1. 2019 онд үзүүлсэн үйлчилгээний тоо, төрлөөр

¹Дэлгэрэнгүй хүснэгтийг Хавсралт 1-т оруулав

Тус мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь 2019 онд нийт 645 удаа дуудлага авч үйлчилгээ үзүүлсний 401 буюу 62 орчим хувь нь 3-7 сард ногдож байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 3-5, 7-9 саруудад давхардсан тоогоор 63.0 мянган толгой малд хийсний 33 хувийг шүлхий, 17 орчим хувийг цусан халдвартын вакцинд хамрагдсан мал тус тус эзэлжээ. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 4, 6-10 саруудад давхардсан тоогоор 18.8 мянган толгой мал хамрагдсаны 50 орчим хувь нь туулгалт, 38 орчим хувьд угаалга хийсэн бол боловсруулалт хийлгэсэн малын тоо дөнгөж 13 хувийг эзэлж байна. Энэ нь малчдын дийлэнх нь Улаанбаатар хотын зах зээлээс ивомек, дусаалга-экотраз зэргийг өөрсдөө худалдан авч малын эмчид хандалгүйгээр өөрсдөө хийдэгтэй холбоотой. Өнгөрсөн жилд 2000 м2 өвөлжөөндөө ариутгал хийсэн нь дөнгөж 20 орчим өвөлжөө болох ба энэ маш хангалтгүй үзүүлэлт юм. Улирлаас хамаарч сард 1000-2000 л сүүнд, 11-12 саруудад 2000 кг мах, 700 толгой малд мал эмнэлгийн гэрчилгээ бичсэн байна. Ноос, ноолуур, арьс, ширэнд мал эмнэлгийн гэрчилгээ олгохгүй байгаа, эдгээр түүхий эдэд гэрчилгээ олгох замаар орлого нэмэгдүүлэх боломжтой.

3.1. Эрхэм зорилго

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, стандарт, мал эмнэлгийн ерөнхий болон төрөлжсөн үйлчилгээний орчин үеийн шаардлагыг бүрэн хангасан, нэгдүгээр зэрэглэлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж болох.

3.2. Зорилтууд

- Малчидтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх
- Угаалгын ваннтай болох
- Стандартын шаардлага хангасан мал эмнэлгийн үйлчилгээний байр, лабораторитой болох
- Бусад мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтарч ажиллах

4. Маркетингийн төлөвлөгөө

4.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь одоогоор 5 багц бүхий 25 нэр төрлийн үйлчилгээг үзүүлдэг ба цаашид бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх хугацаанд буюу 2020-2023 онуудад тус үйлчилгээнүүдийг үзүүлсэн хэвээрээ байх болно гэж төсөөлөв.

Төв аймгийн Борнуур сум сүүний үнээний фермерийн аж ахуй олонтойгул эх барихын хүндрэл, дэлэнгийн үрэвсэл элбэг тохиолддог байна, мөнтариа ногоо тариалдаг тариалангийн газар ихтэй тул намар, хавар тариалангийн талбайн хаягдал ногоо идэж тэжээлийн хордлого их гардаг зэргээс шалтгаалж дуудлага үйлчилгээ их, зарим өдрөө 70-80 хүртэл дуудлага хүлээн авч үйлчилгээ үзүүлдэг.

Хариуцсан малчин өрхүүдийн малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 10 нэр төрлийн вакцин хийдгээс шүлхий, боом, галзуу, томуу, бруцеллёзын вакцины төлбөрийг улсын төсвөөс, дуут хавдар, цусан халдварт, дотрын халдварт хордлогын вакцины төлбөрийг орон нутгийн төсвөөс, шөвөг яр, сахуугийн вакцины төлбөрийг малчин өөрөө хариуцдаг.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний хүрээнд угаалга, туулгалт, боловсруулалт (ивомек, дусаалга экотраз) хийж үйлчилгээ үзүүлдэг ба зарим малчид

ивомекийг өөрсдөө Улаанбаатрын зах зээлээс олж ирж малын эмчээр бус өөрсдөө хийж эмчилдэг тохиолдол гардаг нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ашиг, орлогод нөлөөлдөг байна.

Хариуцсан малчин өрхүүдийн өвөлжөө бууц, хашаа хороонд ариутгал халдваргүйтгэлийн ажил хийж тодорхой орлого олдог, гэвч дийлэнх малчид ариутгал, халдваргүйтгэл хийлгэж хэвшээгүй байгаа нь шимэгчтэх өвчин буурахгүй, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн чанарт сөргөөр нөлөөлсөөр байна.

Фермерүүд сүүгээ Улаанбаатарын сүүний үйлдвэрүүдэд голдуу тушаадаг, сүүний үйлдвэрүүд нь мал эмнэлгийн гэрчилгээ нэхдэг тул сүү борлуулдаг өрхүүд сүүндээ мал эмнэлгийн гэрчилгээг сайн бичүүлж авдаг. Мал, махыг Улаанбаатар юм уу аймаг, бусад сумын зах зээлд нийлүүлэхийн тулд мал, мах борлуулах болгонд мал эмнэлгийн гэрчилгээ бичүүлнэ. Харин арьс шир, ноос ноолуурын хувьд голдуу дундын наймаачид буюу ченжүүдээр дамждаг, нөгөө талдаа ноолуураас бусад түүхий эдийн үнэ доогуур тул эдгээр бүтээгдэхүүнүүдэд мал эмнэлгийн гэрчилгээ тэр болгон бичүүлээд байдаггүй.

Хүснэгт 11. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл

№	Үйлчилгээний төрөл	№	Үйлчилгээний нэр төрөл	Төлбөр төлөх субъект
1	Дуудлагын үйлчилгээ	1.1	Эх барихын хүндрэл	Малчин
		1.2	Саалийн үнээний дэлэнгийн үрэвсэл	Малчин
		1.3	Тэжээлийн хордлого	Малчин
		1.4	Амьсгалын зам, уушгины үрэвсэл хатгалгаа	Малчин
		1.5	Тураал, тэжээлийн дутагдал	Малчин
		1.6	Ходоод, гэдэсний үрэвсэл, хямрал	Малчин
2	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт	2.1	Шүлхий	Улсын төсөв
		2.2	Боом	Улсын төсөв
		2.3	Дуут хавдар	Орон нутгийн төсөв
		2.4	Цусан халдварт	Орон нутгийн төсөв
		2.5	Галзуу	Улсын төсөв
		2.6	Шөвөг яр	Малчин
		2.7	Сахуу	Малчин
		2.8	Дотрын халдварт хордлого	Орон нутгийн төсөв
		2.9	Томуу	Улсын төсөв
		2.10	Бруцеллөз	Улсын төсөв
3	Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ	3.1	Угаалга	Малчин
		3.2	Туулгалт	Малчин
		3.3	Боловсруулалт	Малчин
4	Ариутгал халдваргүйтгэл		Малын өвөлжөө бууц, хашаа хороо гэх мэт	Малчин
5	Мал эмнэлгийн гэрчилгээ	5.1	Мах	Малчин
		5.2	Сүү	Малчин
		5.3	Амьд мал	Малчин
		5.4	Ноос, ноолуур	Малчин
		5.5	Арьс, шир	Малчин

4.2. Үнийн бодлого

Аливаа бизнесийн байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ үнийг тогтоохдоо тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний өөрийн өртөг, өрсөлдөгч байгууллагын ижил төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, хэрэглэгчдийн худалдан авах чадвар, борлуулалт,

маркетинг, тээвэрлэлттэй холбоотой зардлууд зэрэг олон хүчин зүйлийг харгалзах учиртай юм. Гэвч үндэсний болон хүнсний аюулгүй байдалтай холбоотой, өрсөлдөөний зарчмаар хүн бүр эрхлэх боломжгүй, сумын нутаг дэвсгэрт байгаа малчин өрхүүдийг тус суманд үйл ажиллагаа явуулах мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хувааж авч үйлчилгээ үзүүлдэг зэргээс шалтгаалж үйлчилгээний үнэ тарифыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд бие дааж тогтоох боломжгүй, аймаг бүрийн Мал эмнэлгийн газрын саналаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас (ИТХ) баталж мөрддөг билээ. Төв аймгийн мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний төлбөрийн жишиг үнэлгээг 2015 онд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталж мөрдөж байгаа. Зарим нэг голлох эмчилгээ, үйлчилгээний жишиг тарифыг Хүснэгт 12-т харуулав. Үйлчилгээний энэ тариф бизнес төлөвлөгөөний хугацаанд буюу 2020 онд хэвээр мөрдөгдөнө гэж үзэв.

Хүснэгт 12. Төв аймгийн мал эмнэлгийн үйлчилгээний жишиг үнэлгээ

№	Үйлчилгээний төрөл	Төрөл	Хэмжих нэгж	Төлбөр, төгрөг
1	Үзлэг хийх	Бод	Толгой тутамд	2,000
		Бог	Толгой тутамд	500
2	Булчинд тариа хийх	Бод	Толгой тутамд	500
		Бог	Толгой тутамд	300
3	Дуудлага үйлчилгээ	Бод, Бог	Үйлчилгээний төрөл, хол ойроос хамаарна	18,000-60,000
4	Вакцин тарих	Бод	Толгой тутамд	300
		Бог	Толгой тутамд	200
5	Угаалга хийх	Бод	Толгой тутамд	600
		Бог	Толгой тутамд	250
6	Туулгалт хийх	Бод	Толгой тутамд	250
		Бог	Толгой тутамд	150
7	Боловсруулалт хийх	Бод	Толгой тутамд	250
		Бог	Толгой тутамд	150
8	Ариутгал хийх		м ²	200
9	Мал эмнэлгийн гэрчилгээ олгох	Мах	Кг	40
		Сүү	Л	40
		Бод	Толгой тутамд	2000
		Бог	Толгой тутамд	500

4.3. Идэвхжүүлэлт

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилттэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин хийх, малчдаас дуудлага хүлээн авч мал, амьтанд мал эмнэлгийн төрөл бүрийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ ямар нэгэн идэвхжүүлэлтийн бодлого авч хэрэгжүүлдэггүй, учир нь тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй мал эмнэлгийн нэгжүүд нь малчид, фермерүүдийг байршил болон баг багаар нь хуваан авч ажилладаг тул өрсөлдөөн байхгүй гэж ойлгож болно. Нөгөө талаас сумын Засаг дарга, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малчин гурвын хооронд байгуулсан Гурвалсан гэрээнд малчны гүйцэтгэвэл зохих үүргийг тодорхой заасан нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс үйлчилгээ авахтай холбоотой харилцааг зохицуулж өгсөн байна. Тус гэрээнд малчны гүйцэтгэвэл зохих үүргийг доорх байдлаар тусгажээ, үүнд:

- Халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд графикт хугацаанд мал сүргийг бүрэн хамруулан, малын эмчийн аюулгүй ажиллах нөхцөл боломжийг хангах;
- Засгийн газрын 225 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад тусгагдсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, шимэгчтэх өвчинтэй тэмцэх,

эрүүлжүүлэх арга хэмжээний зардал, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх үйлчилгээний хөлсний зардал, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг баталгаажуулахтай холбогдсон бүх зардлын санхүүжилтийг хариуцах;


- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу малын эмчид өгсөн дуудлагын тээврийн хэрэгслийн шатахууны зардлыг хариуцах;
- Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээнд хамрагдсан малчин өрх шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл, худалдаа хийхдээ мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээг тухайн харьяа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авч үйлчлүүлэх;

Малчдын мөнгөн орлого улирлаас, фермерүүдийн орлого сүүний компаниудын төлбөр төлөх хугацаанаас тус тус хамааралтай байдаг тул тэд мал эмнэлгийн үйлчилгээ, дуудлагын хөлсийг тухай бүр төлж чаддаггүй нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаа, ашиг орлогод сөргөөр нөлөөлж байна. Иймд үйлчилгээний төлбөрийг урьдчилж авах, үүнд гар утасны урьдчилсан төлбөрт үйлчилгээ шиг төлбөрийг малчдын мөнгөн орлого орж ирсэн үед урьдчилж авдаг тогтолцоог нэвтрүүлэх, үүнийг гурвалсан гэрээнд тусгаж өгөх нь зүйтэй.

4.4. Борлуулалт, түгээлт

Борсүмбэр ХХК нь Борнуур сумын 3-р баг буюу Бичигт багийн малчин болон мал бүхий 275 өрхийн нийт 36.2 мянган толгой малд эмчилгээ, оношилгоо хийдэг. Малыг төрлөөр нь авч үзвэл 2019 онд адуу 4.1, үхэр 5.6, хонь 13.5, ямаа 13.0 мянган толгой тус тус тоологджээ. Тус баг нь сумын хамгийн олон үхэртэй баг бөгөөд фермерийн аж ахуй эрхэлдэг өрхийн тоо олонтой.

Тус мал эмнэлгийн нэгжийн хариуцдаг Бичигт багийн малын тоо 2012 оноос хойш жил бүр дунджаар 4 хувиар нэмэгджээ, үүнд 2017, 2018 онд өвөлжилт хүндэрч малын хорогдол их гарсан нь нөлөөлсөн. Малын төрлөөр авч үзвэл адуу 9.1, үхэр 5.2, хонь 3.7, ямаа 3.3 хувиар тус тус жил бүр өссөн байна. Нийт малын тоог 2025 он хүртэл жил бүр дунджаар 4 хувиар нэмэгдэнэ гэж тооцож үзэхэд 2022 он гэхэд тус нэгжийн хариуцах малын тоо 39.5 мянга болохоор байна. (Зураг2)



Зураг 2. Бичигт багийн малын тооны өөрчлөлт

5. Үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөө

5.1. Үйл ажиллагааны төлөвлөгөө

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн жилийн үйл ажиллагааны графикыг Хүснэгт 13-т харуулав. Дуудлага үйлчилгээ 1-4, 10-12 саруудад хамгийн их 5-9 саруудад харьцангуй бага бол энэ хугацаанд буюу 4-9 саруудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, шимэгчтэх өвчнөөс сэргийлэх эмчилгээ, угаалга, туулга, боловсруулалт хийдэг байна. Ариутгал, халдваргүйтгэлийг 4-5, 9 саруудад хийж, мал эмнэлгийн гэрчилгээг сүүний хувьд жилийн турш, мах, арьс ширний хувьд 11-12, амьд малын тухайд 4-5, 11-12, ноос ноолуурын хувьд 4-7 саруудад бичиж орлого олдог.

Хүснэгт 13. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааны график, жилээр

№	Үйлчилгээний төрөл	Сар											
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
1	Дуудлагын үйлчилгээ												
1.1	Эх барихын хүндрэл												
1.2	Саалийн үнээний дэлэнгийн үрэвсэл												
1.3	Тэжээлийн хордлого												
1.4	Амьсгалын зам, уушгины үрэвсэл хатгалгаа												
1.5	Тураал, тэжээлийн дутагдал												
1.6	Ходоод, гэдэсний үрэвсэл, хямрал												
1.7	Гэмтэл, бэртэл, шарх эмчлэх												
1.8	Эргүүгийн уйланхай авах												
2	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт												
2.1	Шүлхий												
2.2	Боом												
2.3	Дуут хавдар												
2.4	Цусан халдварт												
2.5	Галзуу												
2.6	Шөвөг яр												
2.7	Сахуу												
2.8	Дотрын халдварт хордлого												
2.9	Томуу												
2.10	Бруцеллёз												
3	Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ												
3.1	Угаалга												
3.2	Туулгалт												
3.3	Боловсруулалт												
4	Ариутгал халдваргүйтгэл												
5	Мал эмнэлгийн гэрчилгээ												
5.1	Мах												
5.2	Сүү												
5.3	Амьд мал												
5.4	Ноос, ноолуур												
5.5	Арьс, шир												

2019 онд үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээнд тулгуурлаж 2020-2023 онд үзүүлэх боломжтой үйлчилгээ, тоо хэмжээг Хүснэгт 14-т харуулав.

Цаашид мал сүргийн тоо, толгой нэмэгдэхийн зэрэгцээ хууль, эрх зүйн орчин сайжирч, мал эмнэлгийн талаар авч хэрэгжүүлэх бодлого, чиглэл тодорхой болно, үүнийг дагаж малчид, мал бүхий иргэдийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр үйлчлүүлэх ухамсар, давтамж нэмэгдэнэ, энэ хэрээр дуудлага үйлчилгээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, шимэгчтэх өвчнөөс сэргийлэх үйлчилгээнд хамруулах малын тоо, ариутгал халдваргүйтгэл хийх талбайн хэмжээ, мал эмнэлгийн гэрчилгээ олгох малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн хэмжээ нэмэгдэнэ гэж тооцоолов. Үүнд, дуудлага үйлчилгээний тоо, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамрагдах малын тоо тус бүрийг жил бүр 10 хувиар нэмэгдүүлж тооцсон. Ариутгал халдваргүйтгэл хийх талбайг 2020 онд 10, 2021 онд 20, 2022 онд 30 хувиар тус тус нэмэгдүүлж, 2021 он гэхэд ядаж 35 орчим өрхийн өвөлжөөнд ариутгал хийх болно гэж төсөөлөв. Мал эмнэлгийн гэрчилгээ олгох сүүний хэмжээг 2020 онд 10, 2021 онд 20, 2022 онд 30 хувиар, махны хэмжээ, малын тоог 2020 онд 20, 2021 онд 30, 2022 онд 50 хувиар тус тус нэмэгдүүлж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ гэж үзсэн болно.

Хүснэгт 14. Үйлчилгээний төрөл, тоо хэмжээ

№	Үйлчилгээний төрөл	2019	2020	2021	2022
1	Дуудлагын үйлчилгээ, удаа	645	682	719	759
1.1	Эх барихын хүндрэл	146	157	168	180
1.2	Саалийн үнээний дэлэнгийн үрэвсэл	156	167	178	189
1.3	Тэжээлийн хордлого	150	160	170	182
1.4	Амьсгалын зам, уушгины үрэвсэл хатгалгаа	52	54	56	58
1.5	Тураал, тэжээлийн дутагдал	54	57	60	63
1.6	Ходоод, гэдэсний үрэвсэл, хямрал	44	44	44	44
1.7	Гэмтэл, бэртэл, шарх эмчлэх	25	25	25	25
1.8	Эргүүгийн уйланхай авах	18	18	18	18
2	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамрагдах малын тоо, толгой	63273	69594	76550	84199
2.1	Шүлхий	21099	23208	25528	28080
2.2	Боом	6307	6937	7630	8392
2.3	Дуут хавдар	1600	1760	1936	2129
2.4	Цусан халдварт	11064	12168	13384	14722
2.5	Галзуу	9400	10340	11374	12511
2.6	Шөвөг яр	1991	2190	2409	2649
2.7	Сахуу	200	220	242	266
2.8	Дотрын халдварт хордлого	7128	7840	8624	9486
2.9	Томуу	400	440	484	532
2.10	Бруцеллэз	4084	4491	4939	5432
3	Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, толгой	18795	20674	22741	25011
3.1	Угаалга	7055	7760	8536	9389
3.2	Туулгалт	9300	10230	11253	12378
3.3	Боловсруулалт	2440	2684	2952	3244
4	Ариутгал халдваргүйтгэл хийх талбай, м2	2000	2200	2640	3432
5	Мал эмнэлгийн гэрчилгээний тоо	19700	21940	26652	33246
5.1	Мах	2000	2400	3120	4680
5.2	Сүү	17000	18700	22440	26928
5.3	Амьд мал	700	840	1092	1638

5.2. Түүхий эд, материалын төлөвлөгөө

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үндсэн түүхий эд, материал нь малын эм, тариа, тос, дусаалга, тэжээлийн нэмэлт витамин, нэг удаагийн зүү, тариур, бээлий зэрэг байх бөгөөд эдгээрийг шаардлага гарсан үед Улаанбаатар хот дахь Монветмед ХХК, Малчин Монгол ХХК, Чонос импрайд ХХК, Агриматко-Монгол ХХК, Глобал бизнес линк ХХК, Монгол Ви.И.Ти.Нет ТББ зэрэг аж ахуйн нэгжүүдээс авдаг. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг Аймгийн Мал эмнэлгийн газраас төлөвлөгөө, графикийн дагуу татаж авна.

Эм, тариа, бусад түүхий эд материалыг олон төрлөөр, их хэмжээгээр авдаг тул үйлчилгээний төрлөөр нь 12 бүлэгт хувааж, нийт мөнгөн дүнгээр нь тооцож гаргав. Үүнийг санхүүгийн тооцоо хэсэгт оруулсан болно.

6. Менежментийн төлөвлөгөө

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь нэг хүний эзэмшлийн, бараг л малын эмч (захирал) нь дангаараа буюу нэг л хүн ажилладаг, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, туулга, угаалга хийх үед түр хугацаагаар туслах авч ажиллуулдаг, зохион байгуулалтын хувьд маш энгийн бүтэцтэй.

Малын эмч бүх зүйлийг өөрөө ганцаараа хийдэг, өөрөөр хэлбэл компанийн захирлын ч, ажилчны ч үүргийг дангаараа хариуцдаг. Үүнд, өдөр шөнөгүй утсаар зөвлөгөө өгнө, дуудлага авна, дуудлагын дагуу явж эмчилгээ, оношилгоо хийнэ, эмийн сангаа ажиллуулна, тайлан тооцоогоо гаргана, жолоочоо хийнэ гэх мэт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүх ажлыг нэг хүн хийдэг. Үүнээс болж маш их ядрах, стрессддэг, бүр утсаар ярихаас хүртэл төвөгшөөж, мал эмнэлгийн ажлыг хийх урамгүй болох үе ч олон гардаг. Түүнчлэн төлөвлөгөө, тооцоо хийх цаг зав байхгүй, төлөвлөгөө, тооцоогүй ажиллах нь орлого багатай, үр ашиггүй ажиллахад хүргэдэг. Иймд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн өрсөлдөх чадваргүй, амиа аргацаасан байдалтай ажилладаг нэг үндсэн шалтгаан нь **компанийн менежменттэй** холбоотой гэж үзэж болно.


Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь ажил үүргийн хувьд ялгаатай маш олон ажлуудыг хийдэг, ажил үүргийн гүйцэтгэл нь нэлээд өндөр хариуцлага шаарддаг тул тус мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь эхний ээлжинд буюу 2020 оноос байнга ажилладаг малын бага эмчтэй болох нь зүйтэй гэж үзэв. Улмаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ажлыг хөнгөвчлөх, санхүү, хөрөнгө оруулалтын ачааллыг багасгах, орлогыг нэмэгдүүлэхийн тулд 2022 оноос тус суманд үйл ажиллагаа явуулдаг бусад мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтарч мал эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээний систем нэвтрүүлж, зохион байгуулалтын хувьд **нөхөрлөл хэлбэрээр** ажиллах нь оновчтой. Үүнд 2022 он хүртэл бусад нэгжүүдтэй хамтарч сумын мал эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга, нэгдсэн лаборатори байгуулах, бусад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах хөрөнгө оруулалтыг шийдэж, зохион байгуулалтын асуудлыг цэгцлэх хэрэгтэй.

2022 он хүртэл компанийн малын эмч нь утсаар зөвлөгөө өгөх, нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, мэс засал хийх, компанийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах ажлуудыг хариуцах бол малын бага эмч дуудлага авах, зарим дуудлагын дагуу эмчилгээ, оношилгоо, зарим хялбар мэс ажилбар хийх, эмийн сан ажиллуулах зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, бусад ид ачаалалтай үед түр хугацаагаар туслах ажилтан ажиллуулж болно.

а. 2022 он хүртэл



б. 2022 оноос хойш – нөхөрлөл хэлбэрээр



Зураг 3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн зохион байгуулалтын хэлбэр

2022 он хүртэл шаардлагатай бүх бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулалтын асуудлаа цэгцэлж, холбогдох бичиг баримтуудыг бүрэн бүрдүүлж дууссаны дараагаас сумын бусад мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтарч нөхөрлөл хэлбэрээр ажиллана гэж төлөвлөв. Үүнд, нөхөрлөлийн захирал аль нэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч байж болно эсвэл гаднаас мэргэжлийн менежер буюу гүйцэтгэх захирал томилж ажиллуулж болно. Эдгээр нэгжүүд нь нэгдсэн мал эмнэлгийн байртай, лабораторитой, жижүүрийн буюу нэгдсэн дуудлагын төвтэй, эмийн сантай, үйлчилгээний албатай байна. Нөхөрлөлийн гишүүд буюу мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд оруулсан хувь хэмжээгээр хариуцлага хүлээж, ашиг хүртэх боломжтой. Ингэж зохион байгуулалтад орсноор нэгжүүдийн эмч нарын хөдөлмөрийг хөнгөвчлөх, ажил үүргийг тодорхой болгох, санхүүгийн ачааллыг багасгах, төлөвлөгөө, тооцоогоотой, үр ашигтай ажиллах нөхцөл бүрдэх болно.

7. Хөрөнгө оруулалт, санхүүгийн төлөвлөгөө

7.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хүснэгт 15. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, мянган төгрөг

№	Хөрөнгө оруулалтын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хувь	Эх үүсвэр
1	Угаалгын суурин ванн барих, 6 тн-ы багтаамжтай	ширхэг	1	20,000.0	20,000.0	18%	Орон нутгийн хөгжлийн сан
2	Мал эмнэлгийн барилга, лабораторийн барилга ороод ²	ком	1	50,000.0	50,000.0	44%	Улсын төсөв
3	Нийтлэг шаардагдах багаж, төхөөрөмж	ком	1	25,783.5	25,783.5	23%	МЭҮН
4	Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	ком	1	12,514.0	12,514.0	11%	МЭҮН

²Бүрэнжаргал, С., Болдбаатар, С. (2019) Сумдад загвар мал эмнэлэг байгуулах төслийн жишиг баримт бичиг. Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо.

5	Тавилга, эд хогшил	ком	1	5,179.0	5,179.0	5%	МЭҮН
Дүн					113,476.5		

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид нийт 113.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа бөгөөд эхний ээлжинд угаалгын ванн барих шаардлагатай гэж үзэв. Үүний 44 хувийг мал эмнэлгийн барилга, 23 хувийг шаардлагатай багаж, төхөөрөмжийг шинэчлэх сэлбэх зардал, 18 хувийг угаалгын суурин ванн, 11 хувийг лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, нэмж авах, 5 хувийг тавилга, эд хогшлын хөрөнгө оруулалт эзэлж байна. Угаалгын суурин ванныг барих хөрөнгө сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бариулахаар 2020 оны төсөвт тусгагдсан байна. Үлдсэн хөрөнгө оруулалтын 30 хувийг 2021, 70 хувийг 2022 онд санхүүжүүлэхээр тооцов. Мал эмнэлгийн барилгын хөрөнгө оруулалтын тооцоог “Сумдад загвар мал эмнэлэг байгуулах төслийн жишиг баримт бичиг”-ээс авсан ба үүнийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж одоохондоо бие дааж санхүүжүүлэх боломжгүй тул улсын төсөвт тусгуулах боломжтой гэж үзсэн болно.

7.2. Борлуулалтын орлогын төлөвлөгөө

Борсүмбэр ХХК нь 2019 онд 44.2 сая төгрөгийн орлого олсны 46 хувийг дуудлагын үйлчилгээ, эмийн борлуулалт, 36 хувийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, 9 хувийг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ, 3 хувийг мал эмнэлгийн гэрчилгээ олгох үйлчилгээ, 1 хувийг ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээний орлого тус тус эзэлж байна. Үйл ажиллагааны төлөвлөгөө хэсэгт, Хүснэгт 14-т тусгагдсан үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээтэй уялдаатайгаар олж болох орлогын хэмжээ хамгийн багадаа 2020, 2021 онуудад өмнөх онтойгоо харьцуулахад 8, 2022 онд 9 хувиар тус тус нэмэгдэж, 2020 онд 47.6, 2021 онд 51.5, 2022 онд 56.1 сая төгрөгт хүрэхээр байна.

Хүснэгт 16. Борлуулалтын орлого, мянган төгрөг

№	Үйлчилгээний төрөл	2019	2020	2021	2022
1	Дуудлагын үйлчилгээ, эмчилгээ (эмийн борлуулалт ороод)	20,448.0	21,646.0	22,844.0	24,142.0
2	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт	15,921.0	17,511.5	19,261.7	21,186.2
3	Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ	3,998.8	4,398.5	4,838.3	5,321.2
4	Ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ	400.0	440.0	528.0	686.4
5	Мал эмнэлгийн гэрчилгээ олгох үйлчилгээ	1,410.0	1,624.0	2,036.4	2,785.3
Дүн		44,196.8	47,640.0	51,529.4	56,143.1

7.3. Зардлын төлөвлөгөө

7.3.1. Түүхий эд, материалын зардал

Эм тарианы зардлыг 2020 онд өмнөх оноос 10, 2021 онд 12, 2022 онд 15 хувиар тус тус нэмэгдүүлж авсан болно.

2019 онд 15.6 сая төгрөгийн эм, тариа, бусад зүйлс худалдан авч байсны 34 хувийг халдвар ба үрэвслийн эсрэг, 12 хувийг гадна ба дотор шимэгчийн эсрэг ивермектин, мөн 12 хувийг нэг удаагийн зүү, тариур, ороох, боох материал тус тус эзэлж байна. Эм, тариа, бусад зүйлс худалдан авах зардал 2020 онд 17.1, 2021 онд 19.1, 2022 онд 21.7 сая төгрөгийн зардал тус тус гаргахаар байна.

Хүснэгт17. Эм, тариа, бусад түүхий эд материалын зардлын тооцоо, мянгантөгрөг

№	Эм, урвалжийн төрөл	2019	2020	2021	2022
1	Халдвар ба үрэвслийн эсрэг	5,361.0	5,897.1	6,604.8	7,595.5
2	Гадна шимэгчдийн эсрэг	882.0	970.2	1,086.6	1,249.6
3	Гална шимэгчдийн эсрэг	972.1	1,069.3	1,197.6	1,377.2
4	Дотно ба гадна шимэгчдийн эсрэг (ивермектин)	1,950.0	2,145.0	2,402.4	2,762.8
5	Эрдэс бодис, витамин нөхөх, тамир тэнхээ сайжруулах	799.5	879.5	985.0	1,132.7
6	Дэлэнгийн шарх, үрэвслийн эсрэг	1,156.0	1,271.6	1,424.2	1,637.8
7	Шархны халдвар, үрэвслийн эсрэг	1,541.3	1,695.4	1,898.9	2,183.7
8	Хурдан морины тэжээлийн нэмэлт	415.0	456.5	511.3	588.0
9	Өвчин намдаах, үрэвслийн эсрэг	342.5	376.8	422.0	485.3
10	Арьсны мөөгөнцөрийн халдварын эсрэг	165.0	181.5	203.3	233.8
11	Нүдний салст бүрхүүлийн үрэвслийн эсрэг	118.4	130.2	145.9	167.7
12	Сав агшаах, савны үрэвслийн эсрэг	135.0	148.5	166.3	191.3
13	Нэг удаагийн зүү, тариур, ороох, боох материал	1,806.0	1,909.6	2,013.2	2,125.2
Дүн		15,643.8	17,131.1	19,061.3	21,730.5

7.3.2. Цалингийн зардал

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид одоогоор ганц малын эмч ажиллаж байгаа бөгөөд сарын цалин нь 800.0 мянган төгрөг юм. Харин халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийх үед туслах ажилтан авч ажиллуулдаг бөгөөд үүний хоногийн цалин нь 40.0 мянган төгрөг. 2019 онд цалингийн зардалд, үүнд НДШ, туслах ажилтны хөлс ороод 12.1 сая төгрөг зарцуулжээ. 2020 оноос малын эмч буюу захирлын ажлын ачааллыг багасгах үүднээс малын бага эмч авч ажиллуулахаар тооцсон бөгөөд 2020 онд 600.0, 2021 онд 660.0 мянган төгрөгийн үндсэн цалин олгоно гэж тооцов. Ингээд цалингийн зардалд 2020 онд гэхэд нийтдээ 22.5 сая төгрөг зарцуулахаар байна.

Хүснэгт18. Цалингийн зардал, мянган төгрөг

№	Албан тушаал	2019	2020	2021	2022
1	Малын их эмч буюу захирал	10,800.0	10,800.0	11,880.0	11,880.0
2	Малын бага эмч		8,100.0	8,100.0	8,910.0
3	Туслах ажилтан	1,265.5	1,391.9	1,531.0	1,684.0
Дүн		12,065.5	20,291.9	21,511.0	22,474.0

7.3.3. Хөдөлмөр хамгааллын зардал

Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлд комбинзон, усны гутал, хамгаалалтай гутал, хормогч, амны хаалт, бээлий зэрэг орох бөгөөд улирал бүр солино гэж тооцоход малын эмч, туслах ажилтнуудад 2019 онд 1.2 сая төгрөг зарцуулсан ба 2020 оноос тус зардлыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлж тооцов.

Хүснэгт19. Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн зардал, мянган төгрөг

Зардлын төрөл	2019	2020	2021	2022
Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл	1,200.0	1,320.0	1,452.0	1,597.2

7.3.4. Шатахууны зардал

Дуудлагад явахад шатахууны зардал гарна, голдуу сумын төвийн фермерүүдээс дуудлага ирдэг, хамгийн хол дуудлагад явахад нэг талдаа 50 км байдаг. Иймд нэг дуудлагын дундаж зайг нэг талдаа 25 км гэж үзэхэд 2019 онд 5.8 сая төгрөгийн шатахууны зардал зарцуулжээ.

Хүснэгт20. Шатахууны зардал, мянган төгрөг

Зардлын төрөл	2019	2020	2021	2022
Шатахууны зардал	5,805.0	6,138.0	6,830.5	7,210.5

2020-2022 онуудад дуудлагын тооноос хамаарч шатахууны зардлын хэмжээ 6.1-7.2 сая төгрөгийн хооронд байх юм. Үүнд шатахууны үнийг 2019-2020 онд 1800, 2021-2022 онуудад 1900 төгрөгөөр тооцов.

7.3.5. Цахилгаан, дулааны зардал

2019 онд цахилгаанд 361.4, дулааны зардалд 450.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. 2020 оноос зардлуудыг жил бүр 10 хувиар тус тус нэмэгдүүлж тооцов.

Хүснэгт21. Эрчим хүчний зардал, мянган төгрөг

№	Зардлын төрөл	2019	2020	2021	2022
1	Цахилгааны зардал	361.4	397.6	437.3	481.0
2	Дулааны зардал	450.0	495.0	544.5	599.0
Дүн		811.4	892.6	981.8	1,080.0

7.3.6. Элэгдлийн зардал

Тус компани одоогоор 13.3 сая төгрөгийн багаж хэрэгсэл, эд хогшилтой бөгөөд жилийн элэгдлийн зардлын хэмжээ 1.3 сая төгрөг болох юм. 2020 оноос угаалгын суурин ванн нэмэгдэж, жилийн 4 хувиар элэгдэл нэмж тооцогдож элэгдлийн хэмжээ 2.1 сая төгрөг олж нэмэгдэнэ. Шулуун шугамын аргаар элэгдүүлж байгаа тул үүнээс хойш барилга, байгууламж баригдаж, шинээр багаж, машин, тоног төхөөрөмж авах хүртэл элэгдлийн зардал тогтмол байна.

Хүснэгт22. Элэгдлийн зардал, мянган төгрөг

№	Нэр төрөл	2019		2020-2022	
		Дүн	Элэгдлийн зардал	Дүн	Элэгдлийн зардал
1	Барилга, байгууламж	-		20,000.0	800.0
2	Нийтлэг шаардагдах багаж, төхөөрөмж	7,936.0	793.6	7,936.0	793.6
3	Лабораторийн багаж хэрэгсэл	2,701.0	270.1	2,701.0	270.1
4	Тавилга, эд хогшил	2,696.0	269.6	2,696.0	269.6
Дүн		13,333.0	1,333.3	33,333.0	2,133.3

7.3.7. Харилцаа холбоо, бичиг хэрэг, шуудан илгээжийн зардал

Сар бүр гар утасны зардалд 30.0, бичиг хэрэгт 25.0, шуудан илгээмжийн зардалд 50.0 мянган төгрөг тус тус зарцуулж, жилдээ 960.0 мянган төгрөг гаргаж байгаа. 2020 оноос хойш жил бүр 10 хувиар нэмэгдүүлж тооцов.

Хүснэгт23. Харилцаа холбоо, бичиг хэрэг, шуудан холбооны зардал, мянган төгрөг

№	Зардлын төрөл	2019	2020	2021	2022
1	Харилцаа холбооны зардал	360.0	396.0	435.6	479.2
2	Бичиг хэргийн зардал	300.0	330.0	363.0	399.3
3	Шуудан илгээмжийн зардал	600.0	660.0	726.0	798.6
Дүн		960.0	1,056.0	1,161.6	1,277.8

7.3.8. Зардлын нэгтгэл


Тус компани 2019 онд 39.8 сая төгрөгийн зардал гаргасны 40 орчим хувийг эм, тариа, урвалж, 30 орчим хувийг цалин, 15 орчим хувийг шатахууны зардал тус тус эзэлж байна. Нийт зардлын хэмжээ 2020 онд 51.0 сая төгрөг болж 2019 онтой харьцуулахад 28 хувь буюу 11.2 сая төгрөгөөр огцом өссөн нь малын эмчийн ачааллыг багасгах зорилгоор малын бага эмч ажиллуулахаар тооцсонтой холбоотой юм. Харин 2021, 2022 онуудад өмнөх онтой харьцуулахад 8 орчим хувиар нэмэгдэж байгаа нь голдуу үнийн өсөлттэй холбоотой өсөлт гэж үзэж болно.

Хүснэгт 24. Зардлын нэгтгэл, мянган төгрөг

№	Зардлын төрөл	2019	2020	2021	2022
1	Эм, тариа, бусад түүхий эд материал	15,643.8	17,131.1	19,061.3	21,730.5
2	Цалингийн зардал	12,065.5	20,291.9	21,511.0	22,474.0
3	Хөдөлмөр хамгааллын зардал	1,200.0	1,320.0	1,452.0	1,597.2
4	Шатахууны зардал	5,805.0	6,138.0	6,830.5	7,210.5
5	Эрчим хүчний зардал	811.4	892.6	981.8	1,080.0
6	Элэгдлийн зардал	1,333.3	2,133.3	2,133.3	2,133.3
7	Харилцаа холбоо, бичиг хэрэг, шуудан холбооны зардал	960.0	1,056.0	1,161.6	1,277.8
Дүн		39,837.9	50,982.9	55,152.5	59,525.3

7.4. Үр ашгийн тооцоо

Борсүмбэр ХХК нь 2019 онд 4.4 сая төгрөгийн ашиг олж байсан бол хүн нэмж ажиллуулах болон бусад шалтгаануудын улмаас 2020 онд 3.3, 2021 онд 3.6, 2022 3.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар байна.



Зураг 4. Орлого, зардал, үр ашиг, мянган төгрөг

Дээрх графикаас харахад мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйлчилгээний үнийн тариф үнэхээр бага, хангалттай ашиг олохуйц хэмжээнд хүрэхгүй байгаа нь мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж буй компаниуд бизнестээ хөрөнгө оруулалт хийж зориулалтын байр барих, стандартын шаардлага хангахуйц багаж, хэрэгсэл худалдан авах,

орон тоогоо нэмэх боломжгүйд хүргэж байна. Энэ нөхцөл байдал нь эргээд мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж халдварт, паразаттах өвчний гаралт тархалт нэмэгдэх, хүнсний болон түүхий эд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаа алдагдах зэргээр нийгэм эдийн засагт сөргөөр нөлөөтэй байна.

8. Эрсдэлийн үнэлгээ

Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх явцад олон төрлийн эрсдэл тохиолдож болох бөгөөд эдгээр эрсдэлүүдээс болж ашиг, орлого багасах, үйлчилгээний чанар доголдох, малын эмч, туслах эмч амь нас, эрүүл мэндээрээ хохирох зэргээр компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болно. Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тулгарч болох эрсдлүүд, тус эрсдэлүүдийг даван туулах, бууруулах арга замуудыг Хүснэгт 25-д харуулав.

Хүснэгт 25. Эрсдлүүд, даван туулах, бууруулах арга замууд

№	Эрсдлийн төрөл	Учирч болох эрсдэл	Даван туулах, бууруулах арга зам
1.	Байгаль, цаг уурын эрсдэл	Ган, зуд болон бусад байгалийн гамшиг тохиолдож малын тоо, толгой цөөрөх, малчдын орлого буурах	Байгал цаг уурын эрсдэлийг тооцож малчид, фермерүүдэд мал, сүргээ хорогдол багатай онд оруулах тухай зөвлөгөө өгөх, өвчилсөн мал сүргийг нь эмчлэх, төрөл бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээг үзүүлэх
2.	Үйлдвэрлэлийн хүчин зүйлс	Малын эм, тариа, зүү тариур, ороох, боох материал дуусах, багаж тоног төхөөрөмж эвдрэх, захиалгат вакцин хугацаанаасаа хоцорч ирэх, захиалсан тоо хэмжээндээ хүрэхгүй байх	- Эм, тариа, зүү тариур, ороох, боох материалыг хүрэлцэх хэмжээгээр нөөцлөх, - Багаж, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, - Захиалсан вакцины тоо хэмжээ болон орон нутагт хувиарлагдах хугацааг урьдчилан тооцоолж вакцинжуулалтын ажлыг төлөвлөж ажиллах
		Шатахууны үнэ нэмэгдэх	Шатахууны үнэ нэмэгдэх эрсдэл үүсвэл мал эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэхэд шаардлагатай шатахууныг нөөцлөх
3	Зах зээлийн эрсдэл	Өрсөлдөгч мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд шинээр бий болох, гэрээт малчид болон малын тоо цөөрөх, малын гаралтай түүхий эдийн үнэ буурсаны улмаас малчид үйлчилгээний төлбөрөө төлж чадахгүй болох	- Өөрийн хариуцсан багт өрсөлдөгч мал эмнэлгийн үйлчилгээний нэгж шинээр байгуулагдах нөхцлийг малчид, фермерүүд болон орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагааны хүрээнд хязгаарлах. - Хавар, намрын улиралд малчид түүхий эд борлуулж бэлэн мөнгөтэй болох үед мал эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөрийг урьдчилан авч төлсөн мөнгөний хэмжээгээр мал эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх
4.	Институцитэй холбоотой эрсдэл	Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн талаар явуулах төр засгийн бодлого, хууль эрх зүйн орчин өөрчлөгдөх	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж эхлээд удаагүй байгаа тул мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн талаар явуулах төр,

			засгийн бодлого ойрын 5 жил тогтвортой байна гэж тооцсон.
		Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид тавигдах стандартын шаардлага өндөрсөх	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартыг хангахад хөрөнгө оруулалт ихээр шаардлагатайгаас гадна төр, засгийн зүгээс ямар нэгэн дэмжлэг, туслалцаа байхгүй тул уг стандартын шаардлага өндөрсөх үндэслэл байхгүй.
5.	Хүний нөөцтэй холбоотой эрсдэл	Малын эмч, туслах ажилтан мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх мал, амьнаас хүнд дамжин халдварладаг зооноз өвчний халдвар авах, бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвараа хагас болон бүтэн алдах	Мал эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үедээ хамгаалалтын хувцас хэрэглэлийг зориулалтын дагуу өмсөж хэрэглэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, норм, стандартыг баримталж зооноз өвчний халдвар болон бэртэл гэмтлээс хамгаалах

Зөвлөмж

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн олонхи нь үйл ажиллагаанаасаа олох орлого нь маш бага бөгөөд өдөр тутмын зарлагаа олсон бага хэмжээний орлогоороо аргацаах төдий ажилладаг нийтлэг төрх ажиглагдаж байна. Орлого багатай мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд бизнестээ хөрөнгө оруулж барилга байгууламж, багаж, төхөөрөмжийн шинэчлэл хийж, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулах ямар ч боломжгүй юм. Иймд орлогоо нэмэгдүүлэх, үр ашигтай ажиллахын тулд дараах зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох нь маш чухал юм. Үүнд:

- Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хөрөнгө, санхүү, материаллаг бааз болон үйл ажиллагаагаа нэгтгэн нөхөрлөл байгуулж стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмж, лабораторитой болж тухайн орон нутгийн иргэдэд мал эмнэлгийн үйлчилгээг тасралтгүй, өргөн хүрээтэй хүргэх
- Мал нэг бүрийг угаалга, туулгалт, боловсруулалтанд хамруулах ажлыг зохион байгуулж гэрээт малчдын мал сүргийг бүрэн хамруулах
- Малчдын өвөлжөө, хаваржааны өтөг, бууц, хашаа, хороо, эрчимжсэн аж ахуйн цогцолборыг ариутгал, халдваргүйтгэлд бүрэн хамруулах ба ач холбогдолыг нь сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах
- Мал, амьтны халдваргүй өвчний дуудлага, үйлчилгээ, эмчилгээнд анхаарал хандуулж эмчилгээний орчин үеийн арга зүй нэвтрүүлэх, малчдад түргэн шуурхай үйлчлэх
- Малын эмийн сангийн эмийн нэр, төрөл, нөөц, тоо хэмжээг нэмэгдүүлж чанарын шаардлага хангасан малын эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслээр малчдыг тасралтгүй хангах
- Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, нийтийн хэрэгцээнд нийлүүлж буй мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн (мах-махан бүтээгдэхүүн, сүү-сүүн бүтээгдэхүүн, өндөг, загас гэх мэт) болон түүхий эд (арьс, шир, ноос, ноолуур)-д лабораторийн шинжилгээ хийж чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах замаар нэмүү өртөг бүхий мал эмнэлгийн гэрчилгээ олгох
- Орон нутгийн сум хөгжүүлэх сангийн хөрөнгө болон төсөл, хөтөлбөрт хамрагдаж барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээ сайжруулах, технологийн шинэчлэл хийх, үйлчилгээний нэр төрлөө олшруулах
- Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж мал сүргээ эрүүл байлгахын ач холбогдол, баталгаатай аюулгүй хүнс хэрэглэх боломж нөхцлийн талаар малчид, иргэдэд сурталчилан таниулж мал эмнэлгийн салбарт хандах нийгмийн хандлагыг өөрчлөх
- Улсын болон орон нутгийн төсвөөс олгодог үйлчилгээний хөлсөөс бусад мал эмнэлгийн үйлчилгээний үнэ тарифийг өөрсдийн онцлогтоо тохируулан нэмэгдүүлэх
- Хүний нөөцийн бодлогод анхаарч өөрсдийн залгамж халаагаа бэлтгэх, шинээр төгссөн залуу малын эмч нарыг мал эмнэлгийн үйлчилгээний бизнес эрхлэх санаачлагыг нь дэмжих, хамтарч ажиллах
- Малчидтай байгуулах гэрээндээ өөрчлөлт оруулж мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулинд малчдын үүрэг хариуцлагыг тусгайлан оруулж гэрээг дүгнэдэг болох, орон нутгийн засаг, захиргаатай хамтран малчдыг шагнаж урамшуулах, дэмжлэг үзүүлэх шалгуур үзүүлэлтэд гэрээний биелэлтийг харгалзан үздэг болох
- Эдийн засаг, маркетинг, менежмент, санхүүгийн бүртгэл мэдээллийн талаар сургалтанд хамрагдаж мэдлэг ур, чадвараа сайжруулах, бизнесээ өөрсдөө төлөвлөж, үр ашигтай удирдан зохион байгуулж сурах

Хавсралтууд

Хавсралт 1. Байвал зохих болон байгаа багаж, төхөөрөмжийн жагсаалт, үнийн дүн, мян.төг

№	Нэр	Хэмжих нэгж	Байвал зохих ³			Одоо байгаа		
			Тоо	Жишиг үнэ	Нийт дүн	Тоо	Үнэ	Нийт дүн
Нэг. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээнд нийтлэг шаардагдах багаж, төхөөрөмж								
1	Малын эмчийн яаралтай тусламжийн багц	багц	1	732.0	732.0	1	930.0	930.0
2	Мал угаалгын мотопомп /Автоматс/	ш	1	1,280.0	1,280.0	2	350.0	700.0
3	Эмгэг анатомийн задлангийн багаж	багц	1	565.0	565.0			-
4	Дээж авах, хүргэх зориулалтын сав /3 давхар савлагаатай/	багц	3	150.0	450.0	1	150.0	150.0
5	Мананцаржуулагч/BF-150/	ш	1	1,300.0	1,300.0			-
6	Халдваргүйтгэл, шимэгчгүйтгэлийн бэлдмэлийн сав	ш	1	310.0	310.0			-
7	Малын ээмэгний мэдээлэл уншигч төхөөрөмж	ш	1	162.0	162.0	1	1,500.0	1,500.0
8	Ээмэглэгч бахь	ш	2	15.0	30.0			-
9	RFID чиптэй ээмэг	ш	900	2.4	2,160.0			-
10	Автомат шпирц /5 мл, хуванцар/	ш	2	150.0	300.0	5	150.0	750.0
11	Туулга олгогч /30 мл, хуванцар/	ш	2	145.0	290.0	6	50.0	300.0
12	Халуун хэмжигч /Түргэн оновчтой хэмжилт хийдэг, усны хамгаалалтай/	ш	3	8.5	25.5	3	13.0	39.0
13	Чагнуур /том, жижиг 2 сувагтай/	ш	3	25.0	75.0	2	30.0	60.0
14	Тогшуурын алх	ш	3	5.0	15.0			-
15	Үхрийн хамрын бахь	ш	2	50.0	100.0			-
16	Адуу засах бахь	ш	2	75.0	150.0			-
17	Адууны шүдний тэвх	ш	2	50.0	100.0			-
18	Арьсны зүү	ш	100	0.5	45.0	150	0.5	75.0
19	Уян зүү	ш	100	0.4	35.0	600	0.4	240.0
20	Торкар гуурс	ш	3	20.0	60.0			-
21	Адууны шүдний хуурай	ш	3	45.0	135.0	1	50.0	50.0
22	Адууны шүдний тэвх	ш	3	50.0	150.0			-
23	Мэс заслын багаж /бага овор/	багц	3	200.0	600.0	1	230.0	230.0
24	Эх барихын багаж /бага овор/	багц	3	280.0	840.0	1	260.0	260.0
25	Хамар ходоодны зонд/Гуурс болон фомптой/	ш	1	710.0	710.0			-
26	Зөөврийн хашаа /28 төмөр хавтан/	Иж бүрдэл	1	1,500.0	1,500.0			-

³Бүрэнжаргал, С., Болдбаатар, С. (2019) Сумдад загвар мал эмнэлэг байгуулах төслийн жишиг баримт бичиг. Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо.

27	Мал угаах зөөврийн болон суурин ванн2743х940х1219	ш	1	1,600.0	1,600.0			-
28	Хөргүүр	ш			-	4	663.0	2,652.0
29	Машин /МЭ-ийн үйлчилгээний/	ш	1	20,000.0	20,000.0			-
Дүн					33,719.5			7,936.0
Хоёр. Лабораторийн багаж хэрэгсэл								
1	Хөлдөөгч -20 ⁰ С	ш	1	450.0	450.0			-
2	Электрон жин	ш	1	1,750.0	1,750.0			-
3	Ус нэрэгч	ш	1	380.0	380.0			-
4	pH метр	ш	1	1,650.0	1,650.0			-
5	Усан ванн	ш	1	225.0	225.0			-
6	Центрифуг	ш	1	420.0	420.0	1	536	536.0
7	Микроскоп	ш	1	2,900.0	2,900.0	1	1300	1,300.0
8	Хатаах шүүгээ	ш	1	650.0	650.0	1	650	650.0
9	Автоклав	ш	1	750.0	750.0			-
10	Бактерицид ламп	ш	1	80.0	80.0			-
11	Термостат	ш	1	1,500.0	1,500.0			-
12	Цахилгаан плитка	ш	1	150.0	150.0			-
13	Термометр	ш	2	18.0	36.0			-
14	Автомат пепитка	ш	1	250.0	250.0	2	95	190.0
15	Автомат пепитка	ш	1	300.0	300.0			-
16	Пепитка тавиур/rack	ш	1	65.0	65.0			-
17	Температур ба чийг хэмжигч	ш	1	25.0	25.0	1	25	25.0
18	Спиртэн дэн	ш	2	20.0	40.0			
19	Бодисын шил	ш	50	10.0	500.0			
20	Хуруу шил	ш	150	0.5	75.0			
21	Гигро-термо-анемометр	ш	1	69.0	69.0			-
22	Цусны биохимийн шинжилгээний аппарат	ш	1	1,100.0	1,100.0			-
23	Дээж сэгсрэгч	ш	1	1,850.0	1,850.0			-
Дүн					15,215.0			2,701.0
Гурав. Тавилга, эд хогшил								
1	Бичгийн ширээ	ш	6	450.0	2,700.0	2	150.0	300.0
2	Сандал	ш	6	210.0	1,260.0	4	50.0	200.0
3	Хувцасны шкаф	ш	3	150.0	450.0	1	150.0	150.0
4	Компьютер /суурин/	ш	2	1,100.0	2,200.0	1	780.0	780.0
5	Хэвлэх төхөөрөмж	ш	1	350.0	350.0	1	200.0	200.0
6	Шилэн тавиур	ш	2	170.0	340.0	2	150.0	300.0
7	Шилэн лангуу	ш	2	100.0	200.0	2	170.0	340.0
8	Цахилгаан халаагч	ш	1	75.0	75.0	1	100.0	100.0
9	Шилэн хаалгатай хөргөгч	ш	1	300.0	300.0	1	326.0	326.0
Дүн					7,875.0			2,696.0
Ерөнхий дүн					56,809.5			13,333.0